

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ногооннуур сумын 4 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2023/73/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Өлгий хот  
2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: М.Хуанган  
Утас: 70422954 Цахим хаяг: [khuanganm@audit.gov.mn](mailto:khuanganm@audit.gov.mn)  
Аудитын менежер: Х.Женисбек  
Утас: 70422930 Цахим хаяг: [jenisbekh@audit.gov.mn](mailto:jenisbekh@audit.gov.mn)  
“Анализ старт Аудит” ХХК-ны захирал: Н.Энхтуяа  
Утас: 99075818 Цахим хаяг: [asaudit.mn@gmail.com](mailto:asaudit.mn@gmail.com)  
Аудитор: А.Батжаргал  
Утас: 99291595 Цахим хаяг: [asaudit.zul@gmail.com](mailto:asaudit.zul@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

АГУУЛГА

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	15
4.1 Ерөнхий зүйл .....	15
4.2 Материаллаг байдал.....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
4.5.1 Завсрын аудитын талаар.....	<b>Error! Bookmark not defined.</b>
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	17
5.1 Төлбөрийн акт.....	17
5.2 Албан шаардлага.....	17
5.3 Зөвлөмж .....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ....	<b>Error! Bookmark not defined.</b>

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын стандарт



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

63129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgi@audit.gov.mn

НОГООННУУР СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН 4 ДУГААР  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
А.КУЛИМХАН ТАНАА

2023.09.17 № 76  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ногооннуур сумын ерөнхий боловсролын 4 дугаар сургууль 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ногооннуур сумын ерөнхий боловсролын 4 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй.

**Аудитын гол асуудал**

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамзатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



## **2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

### **2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

## Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>0.00</b>	<b><u>37,278,644.99</u></b>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	0.00	15,931,941.00
312	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	0.00	15,931,941.00
3121	<b>Төгрөг</b>	0.00	15,931,941.00
31211	Төрийн сангийн харилцах	0.00	15,931,941.00
33	<b>АВЛАГА</b>	0.00	9,761,837.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	9,761,837.00
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>686,000.00</b>	<b>11,584,866.99</b>
354	<b>Хангамжийн материал</b>	<b>14,252,518.00</b>	<b>11,584,866.99</b>
35420	Аж ахуйн материал	10,223,453.00	10,128,893.00
35460	Хүнсний материал	3,750,065.00	1,113,973.99
35470	Бусад хангамжийн материал	279,000.00	342,000.00
35600	Мал амьтад	686,000.00	0.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>65,167,298.46</b>	<b><u>63,278,360.03</u></b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	65,167,298.46	63,278,360.03
391	Газар	0.00	0.00
392	<b>Биет хөрөнгө</b>	57,247,698.46	55,358,760.03
39201	Барилга, байгууламж, орон сууц	92,293,084.79	101,293,084.79
39202	Хуримтлагдсан элэгдэл	-52,949,611.94	-67,878,491.90
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	27,796,541.00	34,582,751.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-22,594,344.84	-24,293,084.76
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	17,768,018.00	17,768,018.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-12,891,598.73	-13,939,127.28
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,335,445.00	2,335,445.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,335,445.00	-2,335,445.00
39217	Ном	7,825,610.18	7,825,610.18
393	<b>Биет бус хөрөнгө</b>	7,919,600.00	7,919,600.00
39301	Програм хангамж	206,256.00	206,256.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-206,256.00	-206,256.00
39303	Бусад биет бус хөрөнгө	7,919,600.00	7,919,600.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>65,167,298.46</u></b>	<b><u>100,557,005.02</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b><u>7,989,128.00</u></b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	0.00	7,989,128.00
413	<b>Өглөг</b>	0.00	7,989,128.00
4136	<b>Бусад өглөг</b>	0.00	7,989,128.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	7,989,128.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>80,185,038.46</u></b>	<b><u>92,567,877.02</u></b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	80,185,038.46	92,567,877.02
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	61,302,173.00	61,302,173.00
51101	Өмч: - төрийн	61,302,173.00	61,302,173.00

Ногооннуур сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51102	- хувийн	0.00	0.00
51103	- хувьцаат	0.00	0.00
51104	Халаасны хувьцаа	0.00	0.00
51105	Нэмж төлөгдсөн капитал	0.00	0.00
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	0.00	0.00
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-55,768,394.71	-43,385,556.15
51210	Өмнөх үеийн үр дүн	-55,768,394.71	-55,768,394.71
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	12,382,838.56
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0.00	0.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	74,651,260.17	74,651,260.17
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	0.00	0.00
51600	Нөөцийн сан	0.00	0.00
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>80,185,038.46</u></b>	<b><u>100,557,005.02</u></b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>231,285,698.00</b>	<b>335,457,100.00</b>
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>231,285,698.00</b>	<b>335,457,100.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	223,497,800.00	305,817,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	296,817,600.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	-	9,000,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	223,497,800.00	-
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	4,457,898.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,457,898.00	-
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	3,330,000.00	29,639,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	3,330,000.00	29,639,500.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>254,743,230.34</b>	<b>323,074,261.44</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>254,743,230.34</b>	<b>323,074,261.44</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	247,347,141.34	306,136,621.44
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	179,013,088.00	203,945,336.97
210101	Үндсэн цалин	165,284,088.00	161,473,433.97
210102	Нэмэгдэл	-	37,659,307.00
210104	Урамшуулал	9,191,200.00	4,812,596.00
210105	Гэрээт ажлын хөлс	4,537,800.00	-
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	23,302,000.00	27,779,864.04
210201	Тэтгэврийн даатгал	16,397,800.00	18,616,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,726,000.00	2,190,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,380,900.00	1,752,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	481,100.00	438,100.00

210205	Эрүүл мэндийн даатгал	3,316,200.00	4,782,864.04
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	3,020,290.00	19,064,350.00
210301	Гэрэл, цахилгаан	1,008,500.00	1,456,000.00
210302	Түлш, халаалт	2,011,790.00	16,608,350.00
210303	Цэвэр, бохир ус	-	1,000,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,986,688.00	-
210401	Бичиг хэрэг	127,400.00	
210402	Тээвэр, шатахуун	2,147,488.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	850,200.00	
210404	Ном, хэвлэл	89,100.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	772,500.00	
2105	<b>Нормативт зардал</b>	13,330,160.00	25,978,875.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	101,600.00	-
210502	Хоол, хүнс	12,596,160.00	25,978,875.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	632,400.00	-
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	500,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	151,300.00	-
210702	Дотоод албан томилолт	151,300.00	-
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	589,100.00	1,450,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	189,100.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,450,800.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	23,454,515.34	27,417,395.43
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,125,400.00	7,381,347.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,223,698.00	2,360,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	18,105,417.34	17,675,148.43
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	7,396,089.00	16,937,640.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	7,396,089.00	16,937,640.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7,396,089.00	16,937,640.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(23,457,532.34)</b>	<b>12,382,838.56</b>
145	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>		
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(23,457,532.34)</b>	<b>12,382,838.56</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>231285698.00</b>	<b>326457100.00</b>
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>231285698.00</b>	<b>326457100.00</b>

Ногооннуур сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	223497800.00	296817600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		296817600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	223497800.00	0.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	4457898.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4457898.00	0.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	3330000.00	29639500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	3330000.00	29639500.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>231285698.00</b>	<b>303738949.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>231285698.00</b>	<b>303738949.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>222591198.00</b>	<b>286801309.00</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	172608100.00	213568287.00
210101	Үндсэн цалин	158879100.00	171096384.00
210102	Нэмэгдэл		37659307.00
210104	Урамшуулал	9191200.00	4812596.00
210105	Гэрээт ажлын хөлс	4537800.00	0.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	23302000.00	27377300.00
210201	Тэтгэврийн даатгал	16397800.00	18616600.00
210202	Тэтгэмжийн даатгал	1726000.00	2190200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1380900.00	1752100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	345200.00	438100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3452100.00	4380300.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	2830000.00	10996000.00
210301	Гэрэл, цахилгаан	1008500.00	1456000.00
210302	Түлш, халаалт	1821500.00	8540000.00
210303	Цэвэр, бохир ус		1000000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3779300.00	0.00
210401	Бичиг хэрэг	132400.00	
210402	Тээвэр, шатахуун	2047500.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	808900.00	
210404	Ном, хэвлэл	189100.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	601400.00	
2105	<b>Нормативт зардал</b>	12747100.00	22853735.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	101600.00	0.00
210502	Хоол, хүнс	11981700.00	22853735.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	663800.00	0.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	500000.00	500000.00
210604	Урсгал засвар	500000.00	500000.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	151300.00	0.00
210702	Дотоод албан томилолт	151300.00	0.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	589100.00	1450800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	189100.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		1450800.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	6084298.00	10055187.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4445400.00	7680887.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1638898.00	2374300.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>8694500.00</b>	<b>16937640.00</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	8694500.00	16937640.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8694500.00	16937640.00

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	0.00	22718151.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	0.00	6786210.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	6786210.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	6786210.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		6786210.00
2260	Гадаад эх үүсвэрээр	0.00	0.00
226001	Гадаад эх үүсвэрээр		
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	0.00	6786210.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	15931941.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		15931941.00

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	61,302,173.00	74,651,260.17	-32,310,862.37	103,642,570.80
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	61,302,173.00	74,651,260.17	-32,310,862.37	103,642,570.80
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн			-23,457,532.34	-23,457,532.34
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	61,302,173.00	74,651,260.17	-55,768,394.71	80,185,038.46
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	61,302,173.00	74,651,260.17	-55,768,394.71	80,185,038.46
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	61,302,173.00	74,651,260.17	-55,768,394.71	80,185,038.46
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			12,382,838.56	12,382,838.56
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	61,302,173.00	74,651,260.17	-43,385,556.15	92,567,877.02

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>326,457,100.00</b>	<b>310,525,159.00</b>	15,931,941.00	<b>95.12</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	326,457,100.00	310,525,159.00	15,931,941.00	<b>95.12</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	309,378,200.00	293,587,519.00	15,790,681.00	<b>94.90</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	227,864,900.00	213,568,287.00	14,296,613.00	<b>93.73</b>
210101	Үндсэн цалин	178,568,200.00	171,096,384.00	7,471,816.00	<b>95.82</b>
210102	Нэмэгдэл	44,482,100.00	37,659,375.00	6,822,725.00	<b>84.66</b>
210104	Урамшуулал	4,814,600.00	4,812,528.00	2,072.00	<b>99.96</b>
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	27,377,300.00	27,377,300.00	0.00	<b>100.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	18,616,600.00	18,616,600.00	0.00	<b>100.00</b>
210202	Тэтгэмжийн даатгал	2,190,200.00	2,190,200.00	0.00	<b>100.00</b>
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,752,100.00	1,752,100.00	0.00	<b>100.00</b>
210204	Ажилгүйдлийн даатгал	438,100.00	438,100.00	0.00	<b>100.00</b>
210205	Эрүүл мэндийн даатгал	4,380,300.00	4,380,300.00	0.00	<b>100.00</b>
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	10,996,000.00	10,996,000.00	0.00	<b>100.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,456,000.00	1,456,000.00	0.00	<b>100.00</b>
210302	Түлш, халаалт	8,540,000.00	8,540,000.00	0.00	<b>100.00</b>
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	1,000,000.00	0.00	<b>100.00</b>
2105	<b>Нормативт зардал</b>	23,157,400.00	22,853,735.00	303,665.00	<b>98.69</b>
210502	Хоол, хүнс	23,157,400.00	22,853,735.00	303,665.00	<b>98.69</b>
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	500,000.00	500,000.00	0.00	<b>100.00</b>
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00	0.00	<b>100.00</b>
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,511,800.00	1,450,800.00	61,000.00	<b>95.97</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,511,800.00	1,450,800.00	61,000.00	<b>95.97</b>
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	17,970,800.00	16,841,397.00	1,129,403.00	<b>93.72</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,576,100.00	14,467,097.00	1,109,003.00	<b>92.88</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,394,700.00	2,374,300.00	20,400.00	<b>99.15</b>
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	17,078,900.00	16,937,640.00	141,260.00	<b>99.17</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	17,078,900.00	16,937,640.00	141,260.00	<b>99.17</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	17,078,900.00	16,937,640.00	141,260.00	<b>99.17</b>
13	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>326,457,100.00</b>	<b>326,457,100.00</b>	0.00	<b>100.00</b>

1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	296,817,600.00	296,817,600.00	0.00	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	296,817,600.00	296,817,600.00	0.00	100.00
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	29,639,500.00	29,639,500.00	0.00	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	29,639,500.00	29,639,500.00	0.00	100.00
4	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>			0.00	0.00
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		15,931,941.00	-15,931,941.00	0.00
6	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>			0.00	0.00
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.00
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	19.00	19.00	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	8.00	8.00	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	10.00	10.00	0.00	100.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт төсөв аваагүй

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

#### *Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар*

Ногооннуур сумын ерөнхий боловсролын дөрөвдүгээр сургууль нь боловсрол олгох чиг үүрэгтэй байгууллага. Тус сургууль нь 2022 онд “Бага боловсрол олгох, алдаагүй зөв бичиж зөв уншиж чаддаг, зөв дадал хэвшилтэй хүүхэд төлөвшүүлэх” зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Дээрх зорилгыг биелүүлэхээр дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Сурагчдад стандартаар тогтоосон бага боловсрол эзэмшүүлэх
- Сургалтын хөтөлбөрийн агуулгыг баяжуулах, багшийг чадавхжуулах замаар сургалтын чанар үр дүнг дээшлүүлэх
- Хүүхэд бүрийг хөгжүүлэх: Үүний тулд бие даан сурах арга барилд сургах, авьяас чадварыг нь нээн хөгжүүлэх
- Хүүхдийг төлөвшүүлэх: Үүний тулд эцэг эх,асран хамгаалагчидтай хамтран ажиллах,тэдэнд сурган хүмүүжүүлэх зөвлөгөө өгөх, зөв дадал хэвшилд сургах.
- Сургууль нь хүүхдийн эрхийг дээдэлсэн, ардчилал, шударга ёс, ил тод байдал, хамтын удирдлагын зарчимд тулгуурлан үйл ажиллагаа зохион байгуулна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

#### *Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар*

Ногооннуур сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Ногооннуур сумын ерөнхий боловсролын дөрөвдүгээр сургууль нь Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль болон бусад боловсролын байгууллагуудад мөрдөж байгаа хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

Улсын Их Хурлаас Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлтөөр боловсролын салбарын байгууллагууд улсын төсвөөс санхүүжиж, БСШУС-ын харьяа Боловсролын ерөнхий газарт санхүүгийн тайлангаа нэгтгэлд тушаадаг болсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тухайлбал: Байгууллагаас гарч байгаа тушаал шийдвэр болон байгууллагын даргын тушаал шийдвэрийн хэрэгжилт, хуулийн үндэслэл бусад байгууллага, иргэдээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдал, байгууллагын дотоод ажлын зохион байгуулалт хөдөлмөрийн сахилга, ажлын цаг ашиглалт, байгууллагын ажлын төлөвлөгөөний биелэлт, дээд байгууллагын тогтоол шийдвэрийн биелэлт, байгууллагын удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт зэрэг ажил хамрагдаж байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм. Ногооннуур сумын ерөнхий боловсролын дөрөвдүгээр сургууль 2022 онд шалгалтад хамрагдаагүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ногооннуур сумын ерөнхий боловсролын дөрөвдүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### ***Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар***

Ногооннуур сумын ерөнхий боловсролын дөрөвдүгээр сургуулийн захирлын 2022 оны 3 дугаар сарын 01-ны өдрийн А/11 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашигладаг байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Ногооннуур сумын ерөнхий боловсролын дөрөвдүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 20.3 сая төгрөгөөр буюу 25.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>Б</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3=2-1</b>
<b>Мөнгөн хөрөнгө</b>	0.0	15931.9	15931.9
<b>Авлага</b>	0.0	9761.8	9761.8
<b>Бараа материал</b>	15017.7	11584.9	-3432.8
<b>Үндсэн хөрөнгө</b>	65167.3	63278.4	-1888.9
<b><u>Нийт хөрөнгө</u></b>	<b>80185.0</b>	<b>100557.0</b>	20372.0
<b>Өр төлбөр</b>	0.0	7989.1	7989.1
<b>Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/</b>	80185.0	92567.9	12382.9
<b><u>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</u></b>	<b>80185.0</b>	<b>100557.0</b>	20372.0

Мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө дансанд өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгийн данс оны эцэст 15.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь батлагдсан төсвөөс бараа үйлчилгээний зардал 15.8 сая төгрөгөөр хэмнэснээс үүдэлтэй байна.

Бараа материалын данс 3.4 сая төгрөгөөр буурсан нь түлш шатах тослох материал, хүнсний материалын зарцуулалттай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс 1.8 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 6.7 сая, бусад эх үүсвэрээс 9.0 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авч үндсэн хөрөнгөнд тайлант онд 17.7 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй гэсний дагуу тус сургууль нь 2022-2023 оны төсвийн хүрээний мэдэгдлийг зохих журмын дагуу боловсруулан дээд шатны удирдлагад өгч батлуулсан байна.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 330.0 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 35.0 сая төгрөг, нийт зарлагыг сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийг хянаж Төсвийн төслийн саналаас зардлыг 38.6 сая төгрөгөөр бууруулж 326.4 сая төгрөгөөр баталсан байна.

Ногооннуур сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийн хуваарьт өөрчлөлт оруулсан байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 296.8 сая төгрөгийг улсын төсвөөс, 29.6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 296.8 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 29.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 310.5 сая төгрөг буюу 95.1 хувьтай байгаа нь дотуур байрны хүүхдийн хоол 0.3 сая төгрөг, үдийн хоол 0.1 сая төгрөг, хүүхдэд ээлтэй сургалтын орчин бүрдүүлэх зардлыг 0.7 сая төгрөг, боловсролын стандарт, сургалт төлөвлөгөө хэрэгжүүлэхэд 14.0 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Дотуур байрны үйлчилгээ	39347.50	39003.23	344.28	99.13
2	Эрүүл мэндийн арга хэмжээ	684.20	684.20	0.00	100.00
3	Сургалт семинар	227.50	170.40	57.10	74.90
4	Үдийн цай хөтөлбөр	17078.90	16937.64	141.26	99.17
5	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	7495.00	6786.21	708.79	90.54
6	Боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	1379.40	1344.93	34.47	97.50
7	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	45923.80	45342.40	581.40	98.73
8	Боловсролын стандарт, сургалт төлөвлөгөө хэрэгжүүлэх	184226.30	170161.66	14064.64	92.37
9	Байр ашиглалтын үйлчилгээ	455.00	455.00	0.00	100.00
10	Байр ашиглалтын тогтмол зардалд	29639.50	29639.50	0.00	100.00
	<b>Дүн</b>	<b>326457.10</b>	<b>310525.16</b>	<b>15931.94</b>	<b>95.12</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Ногооннуур сумын ерөнхий боловсролын дөрөвдүгээр сургууль 2022 онд нэмэлт төсөв аваагүй байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Ногооннуур сумын ерөнхий боловсролын дөрөвдүгээр сургууль 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Ногооннуур сумын ерөнхий боловсролын дөрөвдүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар

сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Улаанбаатар хотын “Анализ старт аудит” ХХК-ны аудитор А.Батжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Ногооннуур сумын ерөнхий боловсролын дөрөвдүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Анализ старт аудит” ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 01 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Ногооннуур сумын ерөнхий боловсролын дөрөвдүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 254.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 3.8 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад алдаа, зөрчил илрээгүй.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд Шилэн дансны мэдээллээс шалгах программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгав. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100%.

Тус аймаг дахь Төрийн аудитын газраас 2022 оны 10 сард хийсэн “Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх аудит” нийцлийн аудитаар шилэн данстай холбоотой аливаа зөрчил дутагдал илрээгүй байна.

Ногооннуур сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Ногооннуур сумын ерөнхий боловсролын дөрөвдүгээр сургуульд завсрын аудит хийгдээгүй байна. Өмнөх оны аудитаар 7.1 сая төгрөгийн 2 зөвлөмж, 0.7 сая төгрөгийн 1 албан шаардлага өгөгдсөнийг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/ төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	700.0	1	700.0	100%
Зөвлөмж	2	7086.0	2	7086.0	100%
Нийт дүн	3	7786.0	2	6858.3	100%

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Оны эцсийн авлагын барагдуулалт, нийгмийн даатгалын байгууллагатай хийх тооцоог хянах.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд 26.0 сая төгрөгийн залруулга хийгдсэн.

Санхүүгийн байдлын тайланд нийгмийн даатгалын авлагыг 9.6 сая төгрөгөөр дутуу тайлагнасан, Үр дүнгийн тайланд 6.8 сая төгрөгийн худалдан авсан хөрөнгийг үнэгүй хүлээн авснаар тайлагнасан, цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 9.6 сая төгрөгөөр илүү тайлагнасныг тус тус залруулав.

Аудитаар нийт 4.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

#### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

#### 5.2 Албан шаардлага

Аудитаар дараах 4.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

1. Сургуулийн дотуур байранд 2022 оны 1-12 дугаар сард байрлаж байсан 5142 хүүхэд өдрөөр нийтдээ 22.638.4 сая төгрөгийн хүнсний материал зарцуулсан бөгөөд дотуур байрны хүүхдийн нэг өдрийн хоолны зардалд дунджаар 4403 төгрөг зарцуулж, нэг өдрийн хоолны зардлын норм 3475 төгрөгтэй харьцуулахад өдөрт 928 төгрөгөөр буюу жилийн дүнгээр 4.7 сая төгрөгөөр нормативыг хэтрүүлж зарцуулсан зөрчилд албан шаардлага өгөгдлөө.

#### 5.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



Ногооннуур сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

---